



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 02 сарын 01 өдөр

Дугаар

1/04

Мандалговь

Биеийн тамир, спортын хамтлагийн
удирдах зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.4, 67.5, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13.1.1, 13.1.2, 13.1.3, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газрын даргын 2017 оны А/82 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Биеийн тамир, спортын хамтлаг байгуулах дүрэм”-ийн 3.1, 3.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Биеийн тамир, спортын хамтлагийн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Ж.Баярсайхан

Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн

Х.Дашням

Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

М.Ганчимэг

Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

Б.Пэрэнлэймаа

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Г.Мандах

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ажилтан

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын ажилтан, албан хаагчдын биеийн тамир, спортын үйл ажиллагаа, бие бялдрын чийрэгжүүлэлтийн түвшинг ахиулах, спортын хувцас, хэрэглэл, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх, тухайн чиглэлээр гарсан аливаа асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, удирдан зохион байгуулж ажиллахыг удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2018 оны А/60 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

4813150025